

“ЭРДЭНЭ ГОЛД ИНК” ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХУРААНГУЙ

10,000,000-12,500,000 ширхэг энгийн хувьцаа
(нэгж бүрийг \$0.85 канад доллараар үнэлсэн)

Энэхүү үнэт цаасны танилцуулгын зорилго нь Эрдэнэ Голд Инк (“Хайгуулын Компани”) (цаашид “Компани” гэх) – ийн нэгж бүрийг 0.85 канад доллараар үнэлсэн 10,000,000 – 12,500,000 ширхэг энгийн хувьцаа (“Энгийн хувьцаа”)-г олон нийтэд арилжаалах, танилцуулахад оршино. Нэгж хувьцааны үнийг Компани болон андеррайтерууд зөвшилцсөний дүнд тооцоолсон болно.

	Олон нийтэд танилцуулсан үнэ	Андеррайтерийн шимтгэл ^{(1) (2)}	Компанийн цэвэр орлого ^{(3) (4)}
Нэгж хувьцаа	\$0.85	\$0.06	\$0.79
10,000,000	\$8,500,000	\$595,000	\$7,905,000
12,500,000	\$10,625,000	\$743,750	\$9,881,250

- (1) Андеррайтерууд нь компанийн хувьцааг борлуулсаны дүнд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 7%-ийн шимтгэл авна.
- (2) Шимтгэлээс гадна андеррайтерт үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалж эхэлсэнээс хойш 2 жилийн хугацаанд компанийн нийт гаргаж буй хувьцааны 7%-тай тэнцэх хэмжээний хувьцааг нэг бүрийг \$0.85 канад доллараар худалдан авах боломжтой, шилжүүлэх эрхгүй опцион Олгогдсон.
- (3) Компани нь Андеррайтеруудад олон нийтэд санал болгож дууссанаас хойш 60 хоногийн хугацаанд хэрэгжүүлэх боломжтой нийт гаргаж буй хувьцааны 15%-тай тэнцэх хэмжээний хувьцааг- нэмэлтээр гарган борлуулах эрх олгосон. Энэ нь зах зээлийн үнэ тогтворгүй үед тэнцвэржүүлэх зорилготой бөгөөд энэхүү эрхийг бүрэн хэрэгжүүлсэн тохиолдолд компанийн олон нийтэд танилцуулсан үнэ, андеррайтерийн шимтгэл болон цэвэр орлого тус бүр \$12,218,750, \$855,313, \$11,363,437 болно.
- (4) Үнэт цаасыг олон нийтэд арилжаалахтай холбоотой бэлтгэл үеийн зардлууд болон бусад зардлуудыг үнэт цаасыг арилжаалж олсон орлогоос төлнө. Энэхүү зардлууд нь андеррайтерийн шимтгэл орохгүйгээр \$575,000 байхаар төсөөлсөн.

National Bank Financial Inc., Haywood Securities Inc болон Toll Cross Securities Inc. нь (Андеррайтер буюу төлөөлөгч) “Үнэт цаас арилжаалах төлөвлөгөө”-ний хүрээнд, гэрээний нөхцөл, хариуцлагын дагуу компанийн гаргасан үнэт цаасыг арилжаалах үүрэг хүлээсэн.

Компанийг төлөөлж, хуулийн зөвлөхөөр Patterson Palmer (Канад улс), Lynch & Mahoney (Монгол улс), Андеррайтерийг төлөөлж Goodman and Carr LLP (Канад улс) ажилласан.

Үнэт цаасны танилцуулгын товч

Дараах товч мэдээлэл нь үнэт цаасны танилцуулгад тусгасан дэлгэрэнгүй мэдээллийн хураангуй болно. Цаашид энэхүү дэлгэрэнгүй мэдээлэл, санхүүгийн датаг танилцуулгаас уншихыг зөвлөж байна.

Компанийн тухай:

Эрдэнэ Голд Инк (Хайгуулын Компани) (“Компани”) нь Канадын Бизнес Корпорацийн хуулийн дагуу 2000 оны 06 сарын 27-нд үүсгэн байгуулагдсан.

Компани нь Монгол улсад алт, зэс олборлох зорилгоор ашигт малтмалын ордын хайгуулын үйл ажиллагааг эрхэлдэг. Үйл ажиллагаа нь томоохон алт болон алт-зэсийн ордуудыг бага зардлаар хайгуул хийж илрүүлэхэд төвлөрдөг. Одоогийн байдлаар компани нь нийт 8 төслийн 378,000 га талбайг хамарсан 19 хайгуулын лиценз эзэмшдэг.

1998-2000 оны хооронд Монгол улсад хийгдсэн хайгуулын үйл ажиллагаа нь Айванхоу Майнз компанийн хайн илрүүлсэн Оюу Толгойн төслөөс хойш илүү өргөжиж эхэлсэн. Хайгуулын үйл ажиллагаа эрчимжихэд нөлөөлсөн бусад хүчин зүйлсэд улс төрийн шинэчлэл, БНХАУ-ын металлын зах зээлтэй ойр байдал зэрэг багтана.

Компанийн удирдлага нь Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай хамт олон юм. Компанийн ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал Петер Акерли, Компанийн удирдах албан тушаалтан Крис Кован нар нь 1990 оноос хойш Монгол улсын томоохон хайгуулын төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай.

Компанийн бизнесийн гол стратеги нь удирдлагын туршлагад тулгуурлан ашигт малтмалын ордуудад хайгуул хийж, хөгжүүлэх явдал юм. 2003 оны 12 сарын 15-нд компанийн төслүүд, 2 жилийн хайгуулын хөтөлбөрт Австрали улсын уул уурхайн салбарын зөвлөх Сноуден-ээр дүгнэлт гаргуулан, 2004 оны 02 сарын 19-нд дүгнэлтийг дахин шинэчилсэн. 2004 оны хайгуулын хөтөлбөрт: урьдчилсан өрөмдлөгийн шатанд буй компанийн 5 голлох хайгуулын талбайд хийгдэх ажлууд, үүнээс 3-т урьдчилсан өрөмдлөгийн ажлыг хийх төлөвлөгөөтэй. Үүнээс компанийн Виржин талбай дахь Тэмүүжин бүсэд анхаарлаа хандуулан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Санал болгож буй хамгийн бага хэмжээ: \$8,500,000 (10,000,000 энгийн хувьцаа)

Санал болгож буй хамгийн их хэмжээ: \$10,625,000 (12,500,000 энгийн хувьцаа)

Санал болгож буй үнэ: \$0.85 канад доллар

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт:

2004 оны 02 сарын 29-ны байдлаар компанийн эргэлтийн хөрөнгө \$3,339,000 канад доллар байсан бөгөөд үнэт цаасыг олон нийтэд арилжаалж, татан төвлөрүүлсэн хөрөнгийг доорхи үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн.

Боломжит хөрөнгө	\$10,669,000	\$12,645,250
Эхний жил дэхь голлох талбайн хайгуулын хөтөлбөр (2004)	\$2,667,500	\$2,667,500
Эхний жил дэхь бусад талбайн хайгуулын хөтөлбөр (2004)	\$334,000	\$334,000
Хоёр дахь жил, голлох талбайн хайгуулын хөтөлбөр (2004)	\$3,822,500	\$3,822,500
Хоёр дахь жил, бусад талбайн хайгуулын хөтөлбөр (2004)	\$797,000	\$797,000
12 сарын турш удирдлага болон захиргааын зардал	\$648,000	\$648,000
Эргэлтийн хөрөнгө	\$2,400,000	\$4,376,250
Нийт	\$10,669,000	\$12,645,250

Санхүүгийн мэдээлэл:

Доорхи мэдээлэл нь уг үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн тайлангаас авсан мэдээлэл юм.

	2003.09.30	2002.12.31	2001.12.31
Орлого			
Хүүгийн орлого	\$2,732	\$169	\$1,380
Татварын өмнөх алдагдал	\$393,440	\$91,201	\$303,515
Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан алдагдал	\$0.11	\$0.05	\$0.11
Хөрөнгө	\$751,579	\$445,184	\$101,722
Урт хугацааны өр төлбөр	-	-	-
Эзэмшигчдийн өмч	\$582,354	\$403,170	\$67,257
Хувьцаат капитал	\$1,232,065	\$296,215	\$262,195
Хувь нийлүүлсэн нэмэгдэл	\$49,920	-	-
Хөрвөх өрийн бичиг	-	\$390,150	-
Алдаглал	\$(699,631)	\$(283,195)	\$(194,938)
Ногдол ашиг	-	-	-

2003 оны 10 сараас 2003 оны 12 сарын хугацаанд Компани нь нэгж тус бүрийг \$0.425 канад доллараар үнэлсэн нийт \$3,939,657 канад долларын хаалттай хөрөнгө оруулалт хийн, 9,269,782 энгийн хувьцааг арилжсан.

Эрсдлийн талаар:

- Эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулах нь эрсдлэл өндөртэй гэж үздэг. Энэхүү эрсдэл нь олборлолтын үе шатаас илүү хайгуулын салбарт илүү өндөр байдаг. Компанийн татан төвлөрүүлэх хөрөнгөөр хийгдэх ажлууд нь томоохон хүдрийн биет олоогүй хайгуулын үе шатанд хийгдэх ажлууд юм.
- Эрдсийн хайгуулын үйл ажиллагаа нь эрсдэл өндөр бөгөөд цаашид олборлолт хийгдэх боломжтой хүдрийн биет олно гэсэн баталгаа байхгүй болно.

- Компанийн санхүүжилтийн эх үүсвэр нь хязгаарлагдмал бөгөөд хайгуулын хөтөлбөрийг гүйцэтгэх санхүүжилтийг олох баталгаа байхгүй болно.
- Компанийн хайгуулын үйл ажиллагааг гадаад улсад эрхэлдэг бөгөөд гадаад улсын хууль эрх зүйн эрсдэл бий болох магадлалтай
- Компани болон компанийн охин компаниудад нь даатгашгүй эрсдэл үүсэх магадлалтай. Энэхүү даатгашгүй эрсдэл нь компанийн материаллаг өөрчлөлтөд нөлөөлөх магадлалтай
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд нь уул уурхайн ижил төстэй байгууллагад ажиллах боломжтой ба энэ нь компанид ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй.
- Өрсөлдөгч байгууллагуудаас үүдэн эрдсийн хайгуулын талбай, лиценз авахад эрсдэл үүсч болзошгүй.
- Эрдсийн болон суурь металлын үнийн хэлбэлзэл компанийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэх магадлалтай.
- Компани нь канад доллараар хөрөнгө оруулалт хийн, санхүүжилт татан төвлөрүүлдэг боловч зардлууд нь ам.доллар болон монгол төгрөгөөр хийгддэг нь валютын эрсдэл үүсгэх магадлалтай.

Компанийн хөрөнгийн мэдээлэл:

2002 оны 07 сарын 26-нд компани нь 9 хайгуулын лицензийг эзэмших эрхийг авсан. Энэхүү хайгуулын лицензүүдийн 4 нь урьд IPC болон Java-ийн хайгуул хийж байсан талбайд хамаарна. Лицензүүдийг авах гэрээний хүрээнд охин компани байгуулсан ба энэхүү охин компанийн 60%-ийг компани, 40%-ийг Монголиа Групп эзэмшихээр болсон. 2003 онд нэгж бүрийг \$0.425 ам доллараар үнэлсэн 800,000 ширхэг энгийн хувьцаа, 1,200,000 варрантийг Монголиа Групп эзэмших болсноор охин компанийг 100% Эрдэнэ Голд Инк эзэмших болсон.

Компанийн 100% эзэмшдэг лицензүүдэд:

1. Блю Спринг проперти (1 лиценз)
2. Рич Гоби проперти (1 лиценз)
3. Туркойз проперти (1 лиценз)
4. Виржин проперти (4 лиценз)
5. Вайт хиллс проперти (1 лиценз)
6. Вайлд Маунтэн проперти (1 лиценз)

Дээрхи лицензээс гадна 2003 оны 03 сарын 12-нд Компани нь Өмнө говь проперти дахь 10,135 га хайгуулын талбайг хамарсан лицензийг 5,000 ам.доллараар авсан. Түүнээс гадна 2003 оны 05 сарын 19 болон 2003 оны 12 сарын 4-нд компани нийт 205,950 га талбайг хамарсан 9 хайгуулын лицензийг авса.

Компанийн удирдлагийн мэдээлэл:

Нэр, оршин суугаа хаяг, Компанид хашиж буй албан тушаал	Голлох албан тушаал	ТУЗ-ийн гишүүн болсон огноо	Эзэмшиж буй үнэт цаас
Петер С.Акерли, Халифакс, Нова Скошиа, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал	Эрдэнэ Голд Инк- ийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал	2003.02.25	364,000 энгийн хувьцаа, 420,000 варрант, 50,000 опцион
Вайн Ж.Бийч, Торонто, Онтарио, ТУЗ-ийн гишүүн	Бийч Хэпбурн хуулийн фирмийн партнер	2003.11.18	120,000 энгийн хувьцаа, 40,000 опцион
Виллиам Б.Буртон, Халифакс Нова Скошиа, ТУЗ-ийн гишүүн	Магнезиум Аллою Корпорацийн ерөнхийлөгч	2003.02.25	24,000 энгийн хувьцаа, 76,000 опцион
Девид С.Б Карнелл, Халифакс, Нова Скошиа, ТУЗ-ийн гишүүн	Бедфорд Капитал Группын ерөнхийлөгч	2003.11.18	240,000 энгийн хувьцаа, 40,000 опцион
Ж.С Кован Торонто, Онтарио, ТУЗ-ийн гишүүн, Үйл ажиллагаа хариуцсан захирал, охин компанийн захирал	Бие даасан зөвлөх	2003.02.25	264,000 энгийн хувьцаа, 180,000 варрант, 40,000 опцион
Кеннет МакДоналд, Халифакс Нова Скошиа, ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч	Фишер Транспорт Лимитед компанийн ерөнхийлөгч	2003.02.25	132,000 энгийн хувьцаа, 118,000 опцион

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:

2004 оны 03 сарын 03-ны байдлаар нэгж тус бүрийг \$0.425 канад доллараар үнэлсэн нийт 9,753,782 энгийн хувьцаа гаргасан. Анхдагч зах зээлд олон нийтэд хувьцааг арилжихаас өмнөх хөрөнгө оруулалтын мэдээллийг доор харуулав.

Огноо	Энгийн хувьцааны тоо	Татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалт	Нэгж хувьцааны үнэ
2000.6 ⁽¹⁾	600,000	\$1,000	(\$0.001665)
2001.6	529,576	\$225,070	(\$0.425)

2001.9	355,552	\$151,110	(\$0.425)
2002.10	102,000	\$43,350	(\$0.425)
2003.1	918,000	\$390,150	(\$0.425)
2003.1	800,000	(2)	(2)
2003.5	484,000	\$205,700	(\$0.425)
2003.10	1,973,250	\$838,631	(\$0.425)
2003.11	240,000	\$102,000	(\$0.425)
2003.12	7,056,532	\$2,999,026	(\$0.425)
Нийт	13,058,910	\$4,956,037	

(1) 2000 оны 6 сард компани нийт 2,000,000 энгийн хувьцааг 2 хувьцаа эзэмшигчдэд арилжиж, \$1,000 хөрөнгө оруулалт татсан. 2001 оны 6 сард дээр дурдсан хувьцаа эзэмшигчид компанид 1,400,000 энгийн хувьцааг буцаан шилжүүлсэн.

(2) Монгол улс дахь лицензийг 100% эзэмших зорилгоор компани нь 800,000 энгийн хувьцаа болон 1,200,000 варрантыг 5 хувьцаа эзэмшигчдэд гаргасан.